

Мөс

Мөсийг юутай ч зүйрлэж боломгүй мэт санагддаг. Мөсний мөн чанарт нэвтэрье гэвэл харах багадна. Барих ч багадна. Харин амтлах хэрэгтэй.

Хэлэн дээрээ тавиад, нүдээ анин зугуухан хүлх. Хүлхэх тусмаа та мөсний ариун тунгалгийг мэдрээд зогсохгүй аливаа шинэ сэргэг юмны шинж нь болсон бусдаас ялгагдах содон сонин нь мэдрэх болно. Шинэхэн цасны үнэр, амтыг зөвхөн мөс л удаан хадгалж чаддаг юм байна ч гэж бодогдож мэднэ. Энэ бүхэнд сатааралгүй цааш нь хүлхэх хэрэгтэй.

Хүлхэн хүлхсээр эцэст нь та зөвхөн мөсөнд л байдаг тэр нэгэн гайхамшигт шинж чанарыг мэдэх болно. Тэр бол идэр есийн жавар. Мөсний чинхүү мөн чанар нь энэ.

Хүлхэх тусам жижигрэх авч дуусан дуустлаа мөнөөх жавраа хадгалан хадгалсаар дуусдаг. Магадгүй, аливаа ариун тунгалаг юм бүхэн өөрийн мөн чанарыг дуусан дуустлаа хадгалдаг ч байж мэднэ.

**1. Эхийн гол санааг илэрхийлсэн өгүүлбэрийг олоорой. \ 4 оноо **

.....

.....

.....

**2. Үгсийг утгатай нь зөв харгалзуул. \ 4 оноо **

- | | |
|-----------------|---------------------------------------------------------|
| 1. Янчаан | А. Аян тээвэр хийж, жин тээж яваа хүмүүс |
| 2. Ганжир | Б. Хуучны хятад зоос |
| 3. Хулд чимэг | В. Сүм дуганы оройд алт, гууль зэрэг төмөрлөгөөр хийсэн |
| 4. Жинчин шувуу | Г. Элээтэй адилавар, бие бяцхан, хулгана зэргийг иддэг |

**3. “Оёдолчдынхоо” гэсэн үгийг утгат хэсгээр задлаарай. \ 4 оноо **

.....

.....

**4. “Зарлага-ын ” гэдэгтэй ижил дүрмээр бичигдэх үг 2-ыг бичээрэй. \ 2 оноо **

.....

**5. “Ногт-л” зөв залгаж бичээд дүрмийг тайлбарлаарай. \ 2 оноо **

.....

.....

.....

**6. Дүрслэх ур маягийг тодорхойлоорой. \ 5 оноо **

Эшлэл	Дүрслэх ур маяг
Ялгуун саарал морин нь тогтож ядан, гуа сайхан дөрвөн хөлөөр ээлжлэн газар цавчилж, уран сайхан толгойгоо ийш тийш сэжихүй нь агаар дор дэгдэж, үүлэн дор умбан алдана.	
Үндэс мөчир бөхтэй Хорхоногийн саглагар мод шиг цэцэглэн ганхаж явсан юм сан.	

Тэр газрын цээжийг аниртан чагнаваас монгол эрсийн нөхөрлөл, гунигт хагацлын тухай эмгэнэлт түүхийг өгүүлнэ.	
Ширмэн төмөр магнайтай, Шивээ хурц хэлтэй, Ган төмөр зүрхтэй, Гадас цүүцэн хошуутай, Галзуу дөрвөн нохой	
Уул мэт бие чинь Нурж одвол Улс орон Монголыг чинь Хэн захирах юм бэ?...	

**7. Тодорхойлолтыг гүйцээгээрэй. \ 2 оноо **

Хүмүүс хоорондын харилцан яриагаар үйл явдал агуулга утга санаагаа нээж үзүүлдэг уран зохиолын бие даасан нэгэн төрлийг гэнэ.

8. Д.Нацагдоржийн “Ламбугайн нулимс” өгүүллэгт ёс суртахуун болон сэтгэлийн ямар зөрчил илэрдэг вэ? Өөрийн үзэл бодлоор тайлбарлаарай.

.....

.....

.....

.....

.....

.....

**9. Галигласан өгүүлбэрийг монгол бичигт хөрвүүлээрэй. \ 5 оноо **

Өгэхү-тэй таргун биши болбачу
Эцэнгхэй мори чу унулг- а

Уруг элигэн төрүл биши болбачу
Итэгэлтэй нөхүр тусатаи

**10. “Эх” сэдэвтэй эх зохион бичээрэй. Үгийн тоо 120-160. \ 10 оноо **

Өс өвөрлөх

Сэтгэлийн талбайд унасан тэнэглэлийн үр. Өөртөө гай тарьсан хүнийг өршөөхөөс илүү, муу муухайгаас зайлах аргагүйг зөвхөн мэргэд, уужуу тэнүүн сэтгэлтнээс бусад нь үл ухаарна. Ихэнх хүмүүс муу муухайг муухайгаар хариулдгаас бусдын буй болгосон муу муухайг улам их болгохоос хэтэрдэггүй.

Нэгэн малчны шөл хийж ууна гэж бодож байсан эргүү төлгийг нь зэрлэг нохой барьчихжээ. Уурлаж хорссон мөнөөх малчин зэрлэг ноходыг буудаж алья гэтэл буугүй учир ноход бариулсан эргүү төлөгнийхөө маханд үнэгний хор хаяад явжээ. Гэтэл хар идсэн зэрлэг нохос галзуурч, нөгөө малчны хоттой хонь, айлынх нь үхэр малыг бүгдийг барьчихжээ.

1.Эхийн гол санааг илэрхийлсэн түлхүүр өгүүлбэрийг бичээрэй.? \ 4 оноо

.....

.....

.....

.....

**2. Үгсийг утгатай нь зөв харгалзуул. \ 4 оноо **

- | | |
|----------------|-------------------------------------------------------|
| 1. Янчаан | А.Аян тээвэр хийж , жин тээж яваа хүмүүс |
| 2.Ганжир | Б. Хуучны хятад зоос |
| 3.Хулд чимэг | В.Сүм дуганы оройд алт,гууль зэрэг төмөрлөгөөр хийсэн |
| 4.Жинчин шувуу | Г.Элээтэй адилавар, бие бяцхан, хулгана зэргийг иддэг |

**3. “Шагналтайгаа” гэсэн үгийг утгат хэсгээр задлаарай. \ 4 оноо **

.....

.....

**4. “Зарлага-ын ” гэдэгтэй ижил дүрмээр бичигдэх үг 2-ыг бичээрэй.\ 2оноо **

.....

.....

**5. “Ногт-л” зөв залгаж бичээд дүрмийг тайлбарлаарай.\ 2 оноо **

.....

.....

.....

**6. Дүрслэх ур маягийг тодорхойлоорой. \ 5 оноо **

Эшлэл	Дүрслэх ур маяг
Ялгуун саарал морин нь тогтож ядан, гуа сайхан дөрвөн хөлөөр ээлжлэн газар цавчилж, уран сайхан толгойгоо ийш тийш сэжихүй нь агаар дор дэгдэж, үүлэн дор умбан алдана.	

Үндэс мөчир бөхтэй Хорхоногийн саглагар мод шиг цэцэглэн ганхаж явсан юм сан.	
Тэр газрын цээжийг аниртан чагнаваас монгол эрсийн нөхөрлөл, гунигт хагацлын тухай эмгэнэлт түүхийг өгүүлнэ.	
Ширмэн төмөр магнайтай, Шивээ хурц хэлтэй, Ган төмөр зүрхтэй, Гадас цүүцэн хошуутай, Галзуу дөрвөн нохой	
Уул мэт бие чинь Нурж одвол Улс орон Монголыг чинь Хэн захирах юм бэ?...	

**7. Тодорхойлолтыг гүйцээгээрэй. \ 2 оноо **

Хүмүүс хоорондын харилцан яриагаар үйл явдал агуулга утга санаагаа нээж үзүүлдэг уран зохиолын бие даасан нэгэн төрлийг гэнэ.

8. Д.Нацагдоржийн “Ламбугайн нулимс” өгүүллэгт ёс суртахуун болон сэтгэлийн ямар зөрчил илэрдэг вэ? Өөрийн үзэл бодлоор тайлбарлаарай.

.....

.....

.....

.....

.....

.....

**9. Галигласан өгүүлбэрийг монгол бичигт хөрвүүлээрэй. \ 5 оноо **

Өгэхү-тэй таргун биши болбачу
Эцэнгхэй мори чу унулг- а

Уруг элигэн төрүл биши болбачу
Итэгэлтэй нөхүр тусатаи

**10. “Тэвчээр” сэдэвтэй эх зохион бичээрэй. Үгийн тоо 120-160. \ 10 оноо **